



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 6/10

Хэрлэн сум

Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж, төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон тул аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, байгууллагын дарга нарын цалинг хавсралтад зааснаар шинэчлэн тогтоосугай.

2. Шинэчилсэн цалин болон бусад нэмэгдлийг холбогдох журамд заасны дагуу 2023 оны 1 дүгээр сарын 01-ээс тооцож олгохыг байгууллагын Няглан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 02 дугаар сарын 13-ны
дугаар захирамжийн хавсралт

АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРЫН
ШИНЭЧИЛСЭН ЦАЛИНГИЙН ЖАГСААЛТ

№	Эцэг/эхийн болон өөрийн нэр	Албан тушаал	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Үндсэн цалин	Орон нутагт ажилласны нэмэгдэл (үндсэн цалингаас)
1	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	T3-4	1088657	20%
2	Г.Нэргүйбаатар	Биеийн тамир, спортын газрын дарга	T3-4	1088657	20%
3	С.Мөнхцэцэг	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	T3-4	1088657	20%
4	Б.Сүнгээ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	T3-4	1088657	20%
5	Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газрын дарга	T3-4	1088657	20%
6	Д.Пүрэвжав	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	T3-4	1088657	20%
7	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	T3-4	1088657	20%
8	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга	T3-4	1088657	20%